



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 10 сарын 05 өдөр

Дугаар 5/78

Чингис хот

Б.Дарханбаатарыг түр орлон гүйцэтгэгчээр
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, 43 дугаар зүйлийн 43.3, 43.3.3, 57 дугаар зүйлийн 57.2, 57.2.2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” 275 дугаар тогтоолын хавсралт, “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, 2019 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”-ын 2.4, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 2019 оны 34/31 дугаартай тушаалаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын 1.5, 1.6, 2.1, 5.1-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өндөржүүлсэн бэлэн байдал зарлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 01 дүгээр зөвлөмжийн дагуу ажлын зайлшгүй шаардлагаар Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт хянуулж, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй Шүүхийн тамгын газрын Шүүхийн үйлчилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Баатарцогтын Дарханбаатарыг 2020 оны 10 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр шилжүүлэн томилсугай.

2. Б.Дарханбаатарын цалинг хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу 1088657 /нэг сая наян найман мянга зургаан зуун тавин долоо/ төгрөгөөр тооцож олгохыг нягтлан бодогч /Э.Ариунтунгалаг/-д зөвшөөрсүгэй.

3. Ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Ж.Гантулга

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

231030337

		2.
Гишүүд:	Ж.Саруултөгс	Хүний нөөцийн удирдлага, агентлаг хариуцсан ахлах мэргэжилтэн
	Ө.Оюунсүвд	Хууль, эрх зүйн хэлтсийн Хууль тогтоомжийн мэдээлэл, системчлэл, дотоод ажил хариуцсан мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Т.Бямбадулам	Архив, бичиг хэргийн эрхлэгч
	Т.Баяртуяа	Нярав

4. Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Б.Дарханбаатарт үүрэг болгосугай.

5. Б.Дарханбаатарт томилогдсоноос хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгээ Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Ж.Гантулга/-т гаргаж өгөх үүрэгтэйг сануулсугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР